| Татаас санхүүжилтийн авлага | 34,129.7 | - | (34,129.7) |
| Зээлийн хүүгийн авлага | 3,630.9 | 1,680.0 | (1,950.9) |
| Байгууллагаас авах  авлага | 209,089.7 | 394,211.9 | 185,122.2 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 123,101.0 | 177,615.9 | 54,514.9 |
| **Дүн** | 840,290.2 | 733,516.6 | (106,773.6) |
| **АВЛАГЫН НИЙТ ДҮН** | 840,290.2 | 733,516.6 | (106,773.6) |

*Эх сурвалж: Дарви сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Ажилчидтай холбоотой авлага 0.5 сая, зээлийн хүүгийн авлага 1.9 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 309.8, татаас санхүүжилтийн авлага 34.1 сая төгрөгөөр бууреч байгууллагаас авах авлага 185.2 сая, хүмүүсээс авах авлагатай холбоотой 54.5 сая төгрөгөөр өсөж  өөрчлөгдсөн байна.

**3.4.3 Урьдчилгаа**

Урьдчилж гарсан хөрөнгийн зардлын эцсийн үлдэгдэл 0 сая төгрөг болж өмнөх оноос 13.3 сая төгрөгөөр буурсан байна. /мянган.төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Урьдчилгаа | 13,330.0 | | (13,330.0) |
| **Дүн** | 13,330.0 | - | (13,330.0) |
| **АВЛАГЫН НИЙТ ДҮН** | 13,330.0 | - | (13,330.0) |

*Эх сурвалж: Дарви  сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилж гарсан зардлын авлага нь өмнөх оны урьдчилгааны ажлыг хүлээж авсантай холбоотой буурсан байна.

3.4.4 **Бараа материал**

Бараа материалын дансны үлдэгдэл 70.4 сая төгрөг болж 296.7 сая төгрөгөөр буурчээ.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Тайлангийн үзүүлэлтүүд | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Түүхий эд материал** | 51,492.5 | - | 51,492.5 | 0.0 |
| Эм боох материал | 44,763.1 | - | 44,763.1 | 0.0 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 6,729.4 | - | 6,729.4 | 0.0 |
| **Хангамжийн материал** | 315,637.8 | 70,378.6 | 245,259.2 | 22% |
| Бичиг хэргийн материал | 2,611.0 | 1,148.0 | 1,463.0 | 0.4 |
| Аж ахуйн материал | 4,835.7 | 3,612.7 | 1,223.0 | 0.7 |
| Хүнсний материал | 28,768.2 | - | 28,768.2 | 0.0 |
| Бусад хангамжийн материал | 224,900.9 | 12,283.9 | 212,617.0 | 0.1 |
| Мал амьтад | 54,522.0 | 53,334.0 | 1,188.0 | 1.0 |
| **Нөөцийн бараа** | | | - | 1.0 |
| **Нийт бараа материал** | 367,130.3 | 70,378.6 | 296,751.7 | 0.2 |

*Эх сурвалж: Дарви сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 68.1 сая төгрөгийн худалдан авалт хийж 0.7 сая төгрөгийн үнэ төлбөргүй материал орлого авч, 67.9 сая төгрөгийн материал зарцуулж 297.6 сая төгрөгийн материал төсөвт байгууллагуудад шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

3.4.5 **Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 9321.1 сая төгрөг байсан бол оны эцэст 2575.9 сая төгрөг болж 6745.2 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 15.0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 974.8 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлогод бүртгэж 6689.9 сая төгрөгийн хөрөнгө балансаас балансt шилжүүлж 223.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

3.4.6 **Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 468.5 сая, эцсийн үлдэгдэл 183.9 сая төгрөг болж 284.6 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад өгөх хөрөнгө оруулалтын ажлын дутуу санхүүжилттэй холбоотой өглөг байна.

3.4.7 **Цэвэр хөрөнгө, өмч**

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 2709.1 сая төгрөг байснаас оны эцэст 662.9 сая төгрөг болж 2046.5 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн баланс шилжсэнтэй холбоотой байна.

3.5 **Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.**1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2849.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2849.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дарви сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04 өдрийн 5/07 тоот тогтоолоор 2849.7 сая төгрөгөөр анх

батализ ирснийг сум ИТХ-ын 2022 оны 06 сарын 24-ны 01/02 тогтоолоор 2849.7 сая төгрөгөөр тодотгол хийн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2849.7 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 886.7 сая, 366.4 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжих, 0.8 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 983.5 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас нийт 2237.5 сая төгрөгөөр санхүүжүүлжээ.

*Хүснэгт 5. Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| Санхүүжилтийн эх үүсвэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,280,795.0 | 1,253,094.6 |
| Орон нутгийн төсвөөс | 914,366.6 | 886,666.2 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 366,428.4 | 366,428.4 |
| Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих | - | - |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | | |
| Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 1,568,935.3 | 984,342.7 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос | 605.0 | 792.0 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос | 487,020.5 | 983,550.7 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 1,081,309.8 | - |
| ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН | 2,849,730.3 | 2,237,437.3 |

*Эх сурвалж: Дарви сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант оны гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 914.4 сая, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 366.4 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.6 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 487.0 сая, оны эхний үлдэгдлээс зарцуулах 1081.3 сая төгрөг нийт 2849.7 сая төгрөгийг тус тус зарцуулах эрх нээлгэж нийт 2237.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 964.5 сая төгрөгийг зарцуулж 1267.5 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс ОНХС-д зарцуулагдаагүй үлдсэн үлдэгдэл 1253.7 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх санд 13.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Аймгийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд 5.5 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 964.5 сая төгрөг буюу 70.7 хувьтай байгаа нь татварын орлогоос аймгийн ерөнхий орлогын дансанд 5.5 сая төгрөг төвлөрүүлж сангийн хөрөнгө зарцуулаагүй дараа онд шилжүүлсэн мөнгөний үлдэгдэлтэй холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая, туслах үйл ажиллагааны орлого 487.0 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.8 сая, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 983.6 сая, нийт 984.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж үндсэн үйл ажиллагааны орлого 0.2 сая төгрөгөөр давж, туслах үйл ажиллагааны орлого буюу зээлийн эргэн төлөлтийн орлого 496.5 сая төгрөгөөр давж биелсэн байна.

*Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл* */сая.төгрөг/*

| Орлогын ангилал | 2022 оны | | Зөрүү |
|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| Татварын нийт орлогын дүн | 1,634.9 | 2,294.4 | (659.5) |
| Нийт орлого ба тусламжийн дүн | 1,147.3 | 1,310.0 | (162.7) |
| Татварын орлого | 1,147.3 | 1,310.0 | (162.7) |
| Орлогын албан татвар | 851.7 | 898.4 | (46.7) |

| | | | |
|---|---|---|---|
| Хувь хүний орлогын албан татвар | 851.7 | 898.4 | (50.00) |
| Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын | 740.7 | 802.6 | (61.9) |
| Үйл ажиллагааны орлого | 24.1 | 34.0 | (9.9) |
| Хөрөнгийн орлого | 52.0 | 44.1 | |
| Хөрөнгө борлуулсны орлого | - | 4.6 | |
| Шууд бус орлого | 34.9 | 13.1 | 21.8 |
| Хөрөнгийн албан татвар | 64.4 | 42.3 | 22.1 |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 6.8 | 6.9 | (0.1) |
| Бууны албан татвар | 2.6 | 2.6 | - |
| Малын тоо толгойн албан татвар | 55.0 | 32.8 | 22.2 |
| Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого | - | - | - |
| Бусад татвар, төлбөр, хураамж | 231.2 | 369.3 | (138.1) |
| Бусад нийтлэг төлбөр, хураамж | 6.0 | 6.5 | (0.5) |
| Улсын тэмдэгтийн хураамж | 3.0 | 2.7 | 0.3 |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны | 2.0 | 1.7 | 0.3 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 1.0 | 2.1 | (1.1) |
| Газрын төлбөр | 222.2 | 359.8 | (137.6) |
| Газрын төлбөр | 222.2 | 359.8 | (137.6) |
| Дуудлага худалдаа | - | - | - |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр | 3.0 | 3.0 | - |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр | | | - |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 2.0 | 2.0 | - |
| Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр | 1.0 | 1.0 | - |
| Татварын бус орлого | 487.6 | 984.4 | (496.8) |
| Нийтлэг татварын бус орлого | 487.6 | 984.4 | (496.8) |
| Бусад орлого | 487.0 | 983.6 | (496.6) |
| Торгуулийн орлого | - | - | - |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 0.6 | 0.8 | (0.2) |

*Эх сурвалж: Дарви сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт орлого 2294.4 сая төгрөг орж 659.5 сая төгрөгөөр давж биелсэн байна.Малын хөлийн татвар 22.2 сая, үл хөдлөхийн албан татвар 22.1 сая төгрөгөөр тасарч цалин хөлс, ашгийн татвар 61.9 сая, хүн амын орлогын албан татвар 50.0 сая, орлогын албан татвар 46.7 сая, газрын төлбөр 137.6 сая, бусад татварын бус орлого 496.6 сая төгрөгөөр давж биелсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.**3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 55.5 сая, дээд шатны төсөв захирагчаас 5.5 сая, засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй орлогоос 69.6 сая нийт 130.6 сая төгрөгийн орлого орж бараа үйлчилгээний бусад зардалд 130.6 сая төгрөг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дарви сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Эрдэнэцэцэг 2023 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 03 дугаар сарын 25–ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 16-ний өдрийн 1/42 албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 4576.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 45.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 60 хувиар буюу 27.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн шатанд нэмж тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсвөөс үр ашиггүй урсгал зардал санхүүжүүлсэн, ИТХ-ын төлөөлөгч зардал анхан шатны баримт хангалтгүй төсөв зарцуулсан зөрчил илэрсэн тул зөрчлийг таслан зогсоох зөвлөмж өглөө.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, ЗДТГ, ИТХ, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн бөгөөд төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийн мэдээллийн 9 гүйлгээ хугацаа хоцроон бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Аудитаар нийт 1278.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 225.3 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 15.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 төлбөрийн акт барагдуулж 525.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага биелүүж алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 512.5 сая төгрөгийн 8 зөвлөмж өгснийг 5 зөвлөмж хэрэгжүүлэн ажиллаж 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

*Хүснэгт* 7. *Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 15.4 | 1 | 15.4 | - | - | 100.0 |
| Албан шаардлага | 2 | 525.1 | 2 | 525.1 | - | - | 100.0 |
| Зөвлөмж | 8 | 512.5 | 5 | 281.5 | 3 | 231.0 | 54.9 |
| **Нийт дүн** | 12 | 1,053.0 | 8 | 822.0 | 3 | 231.0 | 84.9 |

### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэл, хөрөнгийн тооллого хийж хөрөнгө бүртгэсэн эсэх, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг он оноор хөөж авлагыг тооцоо нийлж баталгаажуулсан байдлыг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

## 5. **АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 18.9 сая төгрөгийн алдаа[1] илэрсэн тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Үр дүнгийн тайланд хөрөнгийг үнэ төлбөргүй орлого буруу бүртгэсэнтэй холбоотой 18.9 сая төгрөгийн залруулга санхүүгийн тайланд хийж сумын нэгтгэлд авлаа.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 612.3 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 23.1 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 499.6 сая төгрөгийн 2 албан шаардлага бичиж, 89.6 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

- ✓ *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй төсвийг үр ашиггүй зарцуулсан 204.0 мянга, Төсвийн хэмнэлтийн хууль хэрэгжүүлээгүй тэвчиж болох бэлэг дурсгалын зүйлд 305.5 сая, хэвлэлийн үнэ төлсөн 170.0 мянга, кассын тооцоо хийгээгүй анхан шатны зарцуулсан баримтгүй нийт 679.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалт,*
- ✓ *Засгийн газрын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй ИТХ-ын төлөөлөгч нарт хүчингүй болсон тогтоолоор урамшуулал олгосон 3.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 10-р зүйлийн 10.1.7-д"төсвийн хэрэгжилтэд хяналт тавих, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалт*
- ✓ *Өмнөх онд ISO 9001 стандарт нэвтрүүлэх зардал гаргаж одоог хүртэл хүлээлгэж өгөөгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй хийсэн ажлын тайлан байхгүй 10.0 сая төгрөг, Байгаль хамгаалагчдын хувцас авч сангийн хөрөнгө зориулалт бус зарцуулсан, төрийн хэмнэлтийн хууль хэрэгжүүлээгүй 8.4 сая төгрөг нийт* 18.4 *сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 11-р зүйлийн 11.1-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.*

### 5.2 Албан шаардлага

- ✓ *Сангийн хөрөнгийг иргэдийн санал аваагүй, нийтийн эрх ашигт нийцээгүй хөрөнгийн шинж чанар агуулаагүй урсгал зардалд зарцуулсан, сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалтад тавих дотоод хяналт сул, урьдчилж гарсан зардлын тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, баталгаат хугацааны барьцаа суутгаагүй, СХС-ийн насжилт өндөртэй авлага шийдвэрлээгүй, авлагын үр дүн буурсан, зээлийн үлдэгдлийн тооцоо нийлж баталгаажуулаагүй, нэмэлт ажил магадлангаар баталгаажаагүй төсөв нэмсэн зэрэг 242.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.3-д "үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ой арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардалд", 60.3.4-д нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа", Нягтлан бодох бүртгэлийн*

---

*[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

*тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалт,*

- ✓ *Үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт сул, хөрөнгө үнэгүйдсэн, хөрөнгийн бүртгэл тооцоо хангалтгүй /Виктор 410 комбайн, ХО-аар хэрэгжүүлсэн хөрөнгө/* 256.9 *сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн* 14.2.3-*д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн* 20.2.6-*д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.*

## 5.3 **Зөвлөмж**

### 5.3.1 ***Үйл ажиллагааны зардалтай холбоотой***

*Илрүүлэлт: ИТХ-ын төлөөлөгч нарын сургалтын зардал гэж гаргасан зардлууд анхан шатны баримт дутуу иж бүрэн биш, хэмнэлтийн хуульд нийцээгүй зардал гаргасан, жолоочийн тооцоо байхгүй замын хуудсаар баталгаажуулаагүй шатахуун зарцуулсан, төлөөлөгч нарын шимтгэл бүрэн тооцоогүй 30.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулж дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах,*

### 5.3.2 ***Бараа материалтай холбоотой***

*Илрүүлэлт: Няравын тайлан гаргалт хангалтгүй, шаардах хуудас баталгаажуулаагүй, жолоочийн тооцоо бодоогүй, шатахууны зардал замын хуудсаар баталгаажаагүй, шатахууны орлого харилцахын зардал зөрүүтэй илэрхийлэгдсэн* 33.5 *сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж: Бараа материалын тайланг сар улирлаар гарган, тооллого тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулж ажиллах*

### 5.3.3 ***Өр авлагатай холбоотой***

*Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй ажил гүйлгээ хийсэн, урьдчилж гарсан зардлын авлага, шимтгэлийн өглөг, малжуулах зээлийн авлагын тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, үр ашиггүй зардал гаргаж зарцуулсан* 59.2 *сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах*

*үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж:* *Малжуулах зээлийн үлдэгдлийг баталгаажуулах бусад зардлын авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баримтжуулах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүн мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлсэн санхүүжилт дутуу тайлагнаж санхүүгийн тайлан гаргасан | 1 | 18.9 | | | 1 | 18.9 | 1 | 18.9 | - | - |
| Дүн | 1 | 18.9 | - | - | 1 | 18.9 | 1 | 18.9 | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийт алдаа | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | | | Тоо | Дүн |
| Засгийн газрын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй ИТХ-ын төлөөлөгч нар урамшуулал олгосон | 1 | 3,969.0 | 1 | 3,969.0 | | | | |
| Өмнөх онд ISO 9001 стандарт нэвтрүүлэх зардал гаргаж одоог хүртэл хүлээлгэж өгөөгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй хийсэн ажлын тайлан байхгүй, байгаль хамгаалагч нарт сангийн хөрөнгөөр хувцас авсан | 1 | 18,460.0 | 1 | 18,460.0 | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ИТХ-ын төлөөлөгч нарын сургалтын зардал гэж гаргасан зардлууд анхан шатны баримт дутуу иж бүрэн биш, хэмнэлтийн хуульд нийцээгүй зардал гаргасан, жолоочийн тооцоо байхгүй замын хуудсаар баталгаажуулаагүй шатахуун зарцуулсан, төлөөлөгч нарын шимтгэл бүрэн тооцоогүй | 1 | 30,431.3 | | | | | 1 | 30,431.3 |
| Сангийн хөрөнгийг иргэдийн санал аваагүй, нийтийн эрх ашигт нийцээгүй хөрөнгийн шинж чанар агуулаагүй урсгал зардалд зарцуулсан, сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалтад тавих дотоод хяналт сул, урьдчилж гарсан зардлын тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, баталгаат хугацааны барьцаа суутгаагүй, СХС-ийн насжилт өндөртэй авлага шийдвэрлээгүй, авлагын үр дүн буурсан, зээлийн үлдэгдлийн тооцоо нийлж баталгаажуулаагүй | 1 | 242,762.8 | | | 1 | 242,762.8 | | |
| Үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт сул, хөрөнгө үнэгүйдсэн, хөрөнгийн бүртгэл тооцоо хангалтгүй /Виктор 410 комбайн, ХО-аар хэрэгжүүлсэн хөрөнгө/ | 1 | 256,874.3 | | | 1 | 256,874.3 | | |
| Няравын тайлан гаргалт хангалтгүй, шаардах хуудас баталгаажуулаагүй, жолоочийн тооцоо бодоогүй, шатахууны зардал замын хуудсаар баталгаажаагүй, шатахууны орлого зарлага зөрүүтэй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй | 1 | 59,203.1 | | | | | 1 | 59,203.1 |
| **Дүн** | 6 | 611,700.5 | 2 | 22,429.0 | 2 | 499,637.1 | 2 | 89,634.4 |

## Санхүүгийн тайлангийн аудитын илэрсэн нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ИТХ-ын төлөөлөгч нарт олгосон хоолны зардал төлөөлөгч нарын тооноос илүү зарцуулсан, төлөөлөгч нарт гэж бичиг хэргийн зардал их хэмжээгээр гаргаж төсвийг үр дүнтэй зарцуулаагүй, хэвлэл захиалгын зардалд 480.0 мянга, бэлэг дурсгалд 199.5 мянга, | 1 | 679.5 | 1 | 679.5 | | | | |
| Дүн | 1 | 679.5 | 1 | 679.5 | - | - | - | - |

**Ховд аймаг дах Төрийн аудитын газар**